

СҮХБААТАР АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН 2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН БИЧМЭЛ ТАЙЛАН

2024.10.02

Баруун-Урт

1. Захиргаа, хуулийн тасгийн чиг үүргийн хүрээнд:

Сүхбаатар аймгийн татварын газар нь ТЕГ-аас батлагдсан бүтэц зохион байгуулалтын дагуу 4 тасаг 30 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. 3 орон тооны сул захиалгыг Сүхбаатар аймаг дахь төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн байна.

Манай албанд ирсэн, явсан бичиг, тушаал, шийдвэрийн бүртгэлийг хөтлөхдөө АЕГ-аас хэвлэн гаргасан "Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"-ын дагуу бүртгэл хөтлөн ажилладаг. Мөн office365, ер системийг албан хэрэг хөтлөлтөндөө ашиглан ажиллаж байна. Албан бичгээ цахимжуулах зорилгоор doxc.gov.mn системд бүртгүүлэн ажиллаа. Хос бичгээр албан тоот, захирамжлалын бичгүүдээ баталгаажуулан ажилласан. 2024 оны 3-р улирлын байдлаар ТЕГ-ын даргын А тушаал 18, Б тушаал 5, бусад газраас тогтоол, захирамж, тушаал, албан даалгавар 2, хариутай бичиг 317 цахимаар болон цаасаар ирснийг хүлээн авч бүртгэн газрын даргад танилцуулан цохолт хийлгэн бүртгэл хяналтын карт хөтлөн холбогдох албан тушаалтанд гарын үсэг зуруулан хүлээлгэн өгч хариуг хугацаанд хүргүүлэхэд хяналт тавин ажиллаж хугацаанд нь хариуг хүргүүлсэн бичгийн бүртгэл хяналтын картыг хаалган авч ажиллаа. 119 хариутай бичиг ирснээс 116 нь хугацаа нь бүрэн барагдаж 3 бичгийн хугацаа болооогүй байгаа. Архивын улсын үзлэгтэй холбогдуулан баримт бичгийг нягтлан шалгах, шилжүүлэх баримт бичгийг боловсруулан ажилласан.

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан зорилтуудын хүрээнд Улсын секторын НББ-ын ОУ-ын стандартыг НББ-н үйл ажиллагаанд мөрдлөгө болгож Монгол улсын хууль тогтоомж болон холбогдох тушаал, шийдвэрийн хүрээнд байгууллагад хувиарлагдсан төсвийг зориулалтын дагуу, үндэслэлтэй, үр дүнтэй, зарцуулах, хэмнэх, төрийн өмч ашиглалт хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж ажиллаа.

Хууль тогтоомж болон холбогдох тушаал шийдвэр, цахим төлбөрийн баримтыг үндэслэн тухай бүр санхүүгийн анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж, ажил гүйлгээг бүртгэн, Монгол улсын хууль, тогтоомж, ТЕГ-ын даргын тушаал, Газрын даргын тушаал шийдвэрийг үндэслэн 30 албан хаагчдын цалин хөлсийг сард 2 удаа тооцож тогтоосон хугацаанд олгож ажилласан. Мөн мөнгөн хөрөнгө, бараа материалын орлого зарлагын гүйлгээг тухай бүрд Emerald санхүүгийн программд хөтлөж, төрийн сангийн удирдлагын нэгдсэн системээр ажил, үйлчилгээний төлбөрийн баримтыг үндэслэн мөнгөн хөрөнгийн гүйлгээг тухай бүрд хийж ажилласан.

Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын мэдээллийг цахим системд тухай бүрд байршуулсан үүнд нийт мэдээллэх 183 мэдээллээс сар бүр байршуулах 4 төрлийн мэдээллийг 36 удаа, хагас жил бүр байршуулах 4 төрлийн мэдээллийг 4 удаа, жил бүр байршуулах 11 төрлийн мэдээллээс мэдээлэл байршуулах хуулийн хугацаа болсон 5 төрлийн мэдээ, тухай бүр байршуулах 9 төрлийн мэдээллийг 81 удаа, нийт 126 удаа мэдээллийг байршуулсан.

Жижиг татвар төлөгчтэй харилцах сегментийн хүрээнд:

Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах; татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; төсвийн орлогыг бүрдүүлэх чиг үүргийн хүрээнд ажлаа төлөвлөн зохион байгуулж байна.

Жижиг сегментийн 422 хуулийн этгээдийн бүртгэл, Баруун-Урт сумын 1,3, 8 дугаар багийн 1765 иргэдийн /автотээвэр, галт зэвсэг/ бүртгэлд үндэслэн, ХТМТ-ийн дагуу татварын өр барагдуулах, татварын орлого бүрдүүлэх зөвлөмж, чиглэлийг татварын улсын байцаагчдад хүргүүлж ажиллан, улирал бүр ХТМТ-ийн хэрэгжилтийн тайланг ТЕГ-т хүргүүлж ажиллаа.

Тухайн хугацааны туршид ажлын байраар давхардсан тоогоор 320 гаруй татвар төлөгчдөд татварын хууль тогтоомжоор зөвлөгөө, сурталчилгааг өгч ажилласан байна.

Татварын тайлан хүлээн авалт:

д/д	Татварын төрөл	Ирүүлбэл зохих	Ирүүлсэн	Хувь
1	НӨАТ /6,7,8 сар/	756	756	100,0
2	ААНОАТ / II улирал/	275	275	100,0
3	Цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлан / II улирал/	470	462	98,3
4	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын тайлан / II улирал/	313	313	100,0
5	Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогын албан татварын тайлан / II улирал/	7	6	85,7
6	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан / II улирал/	13	13	100,0
7	АМНАТ / II улирал/	16	16	100,0
	Нийт	1849	1841	99,6

Тайлант хугацаанд ААНОАТ-ын тайлангаар ногдолтой 206, “Х” тайлан 3, НӨАТ-ын тайлангаар ногдолтой 344, “Х” тайлан 19, буцаан олголттой 390 тайлан, Цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлангаар ногдолтой 422 тайланг тус тус хүлээн авсан байна.

2023 оны ААНОАТ-ын 6 тайлан, НӨАТ-ын 13 тайлан, Суутган-1 ..., 2024 оны 2 дугаар улирлын ААНОАТ-ын 16, НӨАТ-ын ...тайланг татвар төлөгчдөд буцаан, ААНОАТ, НӨАТ-ын борлуулалтын орлого зөрүүтэй, чөлөөлөгдөх орлогоо буруу тайлагнасан, зардлаа буруу тусгаж татвар ногдох орлогыг бууруулсан зэрэг зөрчлийн талаар холбогдон заавар зөвлөмж өгч, тайланг засваруулан хүлээн авсан байна.

Тус тасаг нь 2024 оны 3 дугаар улиралд 53 татвар төлөгчтэй холбоотой 687151.2 мянган төгрөгийн хөндлөнгийн мэдээллийг ТУНС-д шивж оруулсан байна.

Тайлант хугацаанд 24 татвар төлөгчийн 594970.5 мянган төгрөгийн өрөнд татварын өр барагдуулах ажиллагааг эхлүүлж, татварын өрийн нэхэмжлэх хүргүүлэн, 3 татвар төлөгчийн 337547.7 мянган төгрөгийн өрийн банкин дахь харилцах дансыг зохих журмын дагуу битүүмжлэн, нийт 13 татвар төлөгчийн 132497.7 мянган төгрөгийн өрийг хураан барагдуулсан байна.

4 татвар төлөгчийн 5821.4 мянган төгрөгийн өрийг бүрэн барагдуулан, 1 татвар төлөгчийн дутуу 44635.6 мянган төгрөгийн өрийг НӨАТ-ийн буцаан олголтоор хаан, нийт 5 татвар төлөгчийн банкин дахь харилцах дансны битүүмжийг цуцалсан байна.

Мөн өмнөх хугацаанд эхлүүлсэн өр барагдуулах ажиллагаанаас 8 татвар төлөгчийн 229676.8 мянган төгрөгийн өрийг барагдуулж ажиллаа.

3 татвар төлөгчийн банкинд дахь харилцах данс, хөрөнгийн байдлыг тогтоохоор Арилжааны банкууд, Аймгийн төрийн сангийн хэлтэс, Улсын бүртгэлийн алба руу албан тоотыг хүргүүлж ажиллав.

Урьд оны тайлангаар ногдуулсан өр 7144813.5 мянган төгрөгийн өрийн 55.6 хувь буюу 3973660.4 мянган төгрөг; - Хяналт шалгалтын актаар ногдуулсан 673271.6 мянган төгрөгийн өрийн 59.1 хувь буюу 397683.1 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Тайлан оны тайлангаар ногдуулсан өр 11240634.8 мянган төгрөгийн өрийн 62.3 хувь буюу 7003339.2 мянган төгрөг; - Хяналт шалгалтын актаар ногдуулсан 619171.1 мянган төгрөгийн өрийн 47.1 хувь буюу 291555.8 мянган төгрөгийг барагдуулсан байна.

НӨАТ-аар 91 татвар төлөгчийг татварт хамруулахаас 98.9 хувь буюу 90 татвар төлөгч, Суутган-1-ээр 399 татвар төлөгчийг татварт хамруулахаас 95.0 хувь буюу 379 татвар төлөгч, ҮХЭХАТ-аар 210 татвар төлөгчийг татварт хамруулахаас 97.6 хувь буюу 205 татвар төлөгч, АТБӨЯХАТ-аар 2290 татвар төлөгчийг татварт хамруулахаас 80.6 хувь буюу 1846 татвар төлөгч тус тус хамруулсан байна. /ААНОАТ, ГЗАТ-ийг жилийн эцсээр тооцно/.

2024 оны 3 дугаар улирлын байдлаар Баруун-Урт - 243, Асгат – 10, Баяндэлгэр – 16, Дарьганга – 16, Мөнххаан – 20, Наран – 10, Онгон – 16, Сүхбаатар – 13, Түвшинширээ – 11, Түмэнцогт – 18, Уулбаян – 10, Халзан – 8, Эрдэнэцагаан – 31 хуулийн этгээд жижиг сегментэд бүртгэлтэй байна.

Тайлант хугацаанд улсын төсвийн орлогод **853449.5** мянган төгрөгийг төвлөрүүлэхээс **855455.1** мянган төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг **100,2** хувиар, аймгийн төсвийн орлогод **2484401,5** мянган төгрөг төвлөрүүлэхээс **5551101.6** мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг **223.4** хувиар биелүүлж ажиллаа.

Хяналт шалгалтын тасаг, Жижиг, бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч нар нь газрын даргын удирдамжийн дагуу НӨАТ-ын хуулийн хэрэгжилт, ибаримт олголтод хяналт тавихаар 9 дүгээр сарын 26-30-ны өдрүүдэд ажиллаж 2 татвар төлөгчид Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэсэн байна.

Ажлын хүрээнд Сүхбаатар худалдааны төв - 21, Марал зоогийн газар - 1, Хонгорзул бөс барааны дэлгүүр - 1, Өгөөмөр төв – 4, Тунамал төв – 5, Чандмань төв – 3, Есэн-Эрдэнэ төв - 6, Таван-Эрдэнэ төв – 8, нийт 49 татвар төлөгчдөд зөвлөгөө өгөн, хугацаатай шаардлага өгч ажиллав. Мөн QR -д бүртгэлгүй 2 татвар төлөгчийг дуудан ирүүлж, зөвлөгөө өгөв.

Зүүн бүсийн худалдааны төв, Хоймор төв, Малчин дэлгүүр зэрэг татвар төлөгчдөд БТТХТ, хяналт шалгалтын тасгаас ажлын хэсгүүд ажилласан байна.

Бичил сегментийн хүрээнд:

Бүртгэлийн талаар:

Улсын бүртгэлд бүртгүүлсэн 52, алба хооронд шилжсэн 1, мэдээлэлд өөрчлөлт оруулсан 49, нийт 102 хуулийн этгээдийг татварын удирдлагын нэгдсэн системд 100% бүртгэсэн.

Хасалт хийлгэх 9 ААН-ийн материалыг ТЕГ-т хүргүүлж эрсдэл тооцуулсан. Үүнээс 3 ААН-ийн тооцооллын үлдэгдлийг баталгаажуулж хасалтын картыг олгосон.

Галт зэвсгийн албан татвар төлөгч 1 иргэнийг хасаж 1 иргэнийг шинээр бүртгэсэн.

АТБӨЯХАТ-ийн шинээр дугаар авсан 21, мэдээлэл шинэчилсэн 36 тээврийн хэрэгслийн мэдээллийг тус тус шинэчилж ТУНС-д бүртгэсэн. АТҮТ-ийн тодорхойлолтоор хасагдсан 15 тээврийн хэрэгслийн тооцооллыг тулгаж ТУНС-д хасалтыг хийсэн.

Үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгчөөр 2 хуулийн этгээд, 4 иргэнийг шинээр бүртгэж 1 иргэний хөрөнгийн хасалт хийсэн байна.

1. Тайлан хүлээн авалтын талаар:

д/д	Татварын төрөл	Ирүүлбэл зохиx	Ирүүлсэн	Хувь
-----	----------------	-------------------	----------	------

1	ААНОАТ /II улирал/	658	604	91.2
2	Цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлан / II улирал/	1279	1263	98.7
3	НӨАТ /7,8,9 сар/	381	377	99.0
4	АМНАТ / II улирал/	3	3	100.0
	Нийт	2321	2247	96.8

Тухайн улиралд ирүүлсэн 2247 тайлангаас ААНОАТ – 25 , НӨАТ – 10, ЦХХТАО – 21, нийт 56 тайланг татвар төлөгчид буцаан засварлуулан хүлээн авсан байна. Нийтлэг гарч буй алдаа нь ААНОАТ, НӨАТ-ын борлуулалтын орлого зөрүүтэй, чөлөөлөгдөх борлуулалтаа төлбөрийн баримт үүсгэхдээ татвар ногдохоор үүсгээд тайланд чөлөөлөгдөх орлогоор тайлагнадаг, зардлаа буруу тусгаж татвар ногдох орлогыг бууруулсан, ХХОАТ-ын тайланд НДШ-ын хувь хэмжээг буруу тооцдог, татварын хөнгөлөлтийг буруу тооцдог зэрэг зөрчил дийлэнхи хувийг эзэлж байна.

Тайлан ирүүлбэл зохих судалгааг шинэчилж 2-3 жил тайлан ирүүлээгүй 9 ААН-ийн улсын бүртгэлд бүртгэлтэй, татан буугдсан, хасагдсан эсэх талаар түүхчилсэн лавлагааг авахаар Улсын бүртгэлийн хэлтэсрүү хүргүүлсэн.

3. Сургалт, сурталчилгааны талаар:

ХХОАТ-ийн тухай хууль, Нэвтрэлтийн нэгдсэн систем, Цахим төлбөрийн баримт, Татварын хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага сэдвүүдээр Монгол банкны салбар, Шүүхийн тамгийн газар, Зүүн бүсийн худалдааны төв зэрэг ААНБ, иргэдэд 3 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд 82 татвар төлөгч хамрагдсанийг хүйсээр авч үзвэл эрэгтэй 21, эмэгтэй 61 байна.

Мөн шинээр байгуулагдсан 52 ААН-д ТЕХ болон бусад хуулиар сургалтыг тухай бүр өгч ажилласан.

Төвлөрсөн зах худалдааны төв, хувиараа бизнес эрхлэгч иргэдэд сар бүр график гарган төлбөрийн баримт олголт дээр хяналтыг хийж хэвшсэн ба төлбөрийн баримт олгоогүй 2 иргэнд ЗТХ-ийн дагуу 1750,0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээг авсан байна.

4.Татварын орлого бүрдүүлэлт, татварын өр хураан барагдуулалтын талаар:

Тайлант хугацаанд сумын төсвийн орлогод **4,521,297,4** мянган төгрөгийг төвлөрүүлэхээс **5,034,490.8** мянган төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг **111,4** хувиар биелүүлж ажиллаа.

ХТМТ III-IV түвшиний өртэй 121 татвар төлөгчид 85444.1 мянган төгрөгийн мэдэгдэх хуудас хүргүүлсэн. 15 татвар төлөгчийн 8142.1 мянган төгрөгийг өрийг барагдуулж 80 татвар төлөгчийн 57664.4 мянган төгрөгийн өрөнд арилжааны банкин дахь дансанд хаалтын бичилт хийж 38 татвар төлөгчийн 24819.5 мянган төгрөгийн өрийг хураан барагдуулсан байна.

Урьд оны тайлангаар ногдуулсан өрийн барагдуулалт - 4,577,800 мян төгрөгийн өрөөс 45.9 хувь буюу 2,102,300,0 мян төгрөг; - Хяналт шалгалтын актаар ногдуулсан 50,110.6 мянган төгрөгийн өрийн 23.1 хувь буюу 11,603.4 мянган төгрөгийг тайлант онд барагдуулсан байна.

2024 оны 09 дүгээр сарын 18-наас 09 дүгээр сарын 30-ны хооронд Сүхбаатар аймгийн татварын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/15 дугаар тушаалын дагуу НӨАТ-ын хууль тогтоомжийн хэрэгжилт, төлбөрийн баримт олголт, ТУНС-д холбогдсон байдалд хяналт, шалгалтыг үсчин, гоо сайхан, хэвлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 50 иргэн, ААН-д хийж, төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлэх явцад илэрсэн 5 иргэнд зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр заалтын 8.3 дахь хэсгийг баримтлан 4,500,000.00 төгрөгийн торгууль оногдуулан шийдвэрлэв.

Сүхбаатар аймгийн татварын газар